



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/125

Бөхт

Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээтэй
газрыг эзэмшүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 106 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газарт (9033157)-д төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээний зориулалтаар 500211м² газрыг Манлай овоо хаягт 60 жилийн хугацаатай, төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээний зориулалтаар 500219м² газрыг Дэрсний ус хаягт 60 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Газрын даамал (Б.Нарандэлгэр)-д даалгасугай.

3.Холбогдох хууль тогтоомжийн заалтыг хэрэгжүүлж, газрыг зориулалтын дагуу зөв зохистой эзэмшихийг Засаг даргын Тамгын газар (Б.Амгаланжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



АЛТАНХҮҮ